



## БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

Г 2023 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын  
журам батлах тухай

Боловсролын тухай хуулийн 17<sup>1</sup> дүгээр зүйлийн 17<sup>1.1</sup> дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын "Монгол хэлбичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай" 2013 оны 37 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/20 дугаар тушаалаар батлагдсан "Боловсролын үнэлгээний байгууллагын дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "2023 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг 2023 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын зохион байгуулалтын үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг Үндэсний болон олон улсын үнэлгээний хэлтсийн дарга /М.Гантуяа/, Мэдээлэл технологийн хэлтсийн дарга /Э.Цэрэнцоодол/, Даалгаврын сангийн хэлтсийн дарга /С.Гэндэнжамц/ нарт үүрэг болгосугай.
3. Журмыг байгууллагын цахим хуудас /www.eec.mn/-д байршуулахыг Хэвлэл мэдээллийн мэргэжилтэн /Д.Отгонбаатар/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлагын хэлтсийн дарга /З.Дайриймаа/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



1323010000

## 2023 ОНЫ ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар Монгол Улсын хэмжээнд их, дээд сургууль, коллежид элсэгчдийн мэдлэг, чадварын түвшинг тогтоох Элсэлтийн ерөнхий шалгалт /цаашид ЭЕШ гэх/, эх хэлний боловсролын чанар, хэрэглээ, иргэдийн харилцааны соёл, эх хэлний дархлааны түвшинг тогтоох, сайжруулах зорилго бүхий Монгол хэл бичгийн шалгалт /цаашид МХБШ гэх-/ыг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Их, дээд сургуульд элсэгчдээс авах ЭЕШ-ыг зохион байгуулахад БШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам" болон холбогдох бусад эрх зүйн актыг дагаж мөрднө.
- 1.3 Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол улсын ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэхэд БШУ-ны сайдын 2021 оны А/347 дугаар тушаал-/Олон улсын шалгалтын үнэлгээг элсэлтийн ерөнхий шалгалтын дүн оноотой дүйцүүлэх/-аар батлагдсан журмыг баримтална.
- 1.4 ЭЕШ-ыг 2023 онд бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэн /цаашид энэ онд төгссөн шалгуулагч гэх/, 2023 оноос өмнө бүрэн дунд боловсрол эзэмшсэн болон түүнээс дээш боловсролтой иргэн /цаашид өмнөх онд төгссөн шалгуулагч гэх/ өгнө.
- 1.5 Их, дээд сургуульд элсэн суралцахаар ЭЕШ-д бүртгүүлсэн шалгуулагч нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 1.3, БШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-ын 2.2-т заасны дагуу МХБШ-д заавал хамрагдсан байна.
- 1.6 Монгол хэлбичиг болон ЭЕШ-ыг 2023 онд тус бүр 2 удаа зохион байгуулна.
- 1.7 Шалгуулагч нь ЭЕШ-д монгол хэл, англи хэл, орос хэл, математик, физик, хими, биологи, газар зүй, түүх, нийгэм судлал хичээлээс 2 ба түүнээс дээш хичээлийг сонгоно.
- 1.8 ЭЕШ-ын сэдэв даалгаврыг энэхүү журмын 1.7-д заасан хичээлийн сургалтын хөтөлбөрийн заавал судлах агуулгын хүрээнд боловсруулсан байна.
- 1.9 ЭЕШ-ын монгол хэл, англи хэл, орос хэлний шалгалтын агуулгад сонсоод ойлгох чадварыг шалгах даалгавар 10-15 хувийг эзэлнэ.
- 1.10 ЭЕШ-ын монгол хэлний хичээлийн шалгалтын агуулгын 25 хувь нь үндэсний бичгийн мэдлэг, чадвар сорьсон даалгавар байна.
- 1.11 МХБШ нь монгол хэл, үндэсний бичгийн хэрэглээний чадвар сорьсон сонгох болон задгай хэлбэрийн даалгавраас бурдэнэ.

- 1.12 Зарим хичээлийн сэдэв, даалгаврын тавил, агуулгын тохирцыг тандах зорилгоор шалгуулагчийн дүн оноо, шалгалтын үндсэн цагт нөлөөлөхгүй байдлаар туршин шинжилж болно.
- 1.13 ЭЕШ-ын хичээл бүрийн шалгалтын сэдэв даалгаврыг Боловсролын үнэлгээний төв /цаашид БҮТ гэх/-өөс боловсруулсан блюпринтэд үндэслэн шинээр боловсруулан бэлтгэнэ.
- 1.14 ЭЕШ-ын ерөнхий блюпринтийг олон нийтэд мэдээллийн сувгаар дамжуулан хургэнэ.
- 1.15 МХБШ болон ЭЕШ нь сонгон авсан Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн анги танхим, сургалтын байр /цаашид шалгалтын байр гэх/-нд явагдана.
- 1.16 Шалгалтын байранд хяналтын дуран, сонсгох төхөөрөмж, сүлжээ сарниулагч, металл илрүүлэгч, засагч машин, шууд дамжуулалтын төхөөрөмж гэх мэт шаардлагатай тоног төхөөрөмжийг ашиглана.
- 1.17 Мөн шалгалтын материал засах, оноожуулах явцын ил тод байдлыг хангах зорилгоор шалгалтын байранд шууд засалтын анги танхим бэлтгэх ба шаардлагатай тоног төхөөрөмж ашиглана.
- 1.18 Шалгалтын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон "Элсэгчийн сонин", [www.eec.mn](http://www.eec.mn), <https://www.facebook.com/eec.mn/>, гар утасны ЕЕС аппликейшн, page хуудас, stat.eec.mn, help.eec.mn цахим хуудас, шалгуулагчийн и-мэйлээр тухай бүрд хүргэнэ.
- 1.19 МХБШ болон ЭЕШ-ын сэдэв даалгавар бэлтгэх, хувилах, хүргүүлэх, шалгалтын материалыг төвлөрүүлэн татах, засах, үнэлэхтэй холбоотой нууцлалыг БҮТ хариуцна.
- Хоёр. ЭЕШ-ын бүртгэл**
- 2.1 МХБШ болон ЭЕШ-ын бүртгэлийг [www.eec.mn](http://www.eec.mn) цахим хуудсаар дамжуулан БҮТ-өөс зарласан хугацаанд зохион байгуулна. Бүртгэлийн хугацааг сунгахгүй ба нэмэлт бүртгэл хийхгүй.
- 2.2 Цахимаар бүртгүүлэхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү журмын 1.18-д заасан мэдээллийн эх сурвалжаас авч болно.
- 2.3 Шалгуулагч нь бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:
- 2.3.1 Иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах баримт бичиг /иргэний үнэмлэхийн лавлагаа, гадаад паспорт, цагдаагийн үнэмлэх, мөн гадаадын иргэний Монгол Улсад оршин суух түр үнэмлэх/;
- 2.3.2 Өнгөт цээж зураг /цээж зураг нь 3\*4 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авхуулсан, урагшаа цэх харсан, арын фон нь цайвар цулгүй өнгийн, нарны шил болон малгайгүй байна/;
- 2.3.3 Бүх банкны интернэт гүйлгээ хийх эрхтэй төлбөрийн карт болон Qpay үйлчилгээ бүхий банкны аппликейшн;
- 2.3.4 Шалгуулагч бүр зөвхөн өөрийн и-мэйл хаягаар бүртгүүлнэ.
- 2.4 Өмнөх онд төгссөн шалгуулагч шалгалт өгөх аймаг /хот/-аа өөрөө сонгож бүртгүүлнэ.

2.5 Бүртгэл баталгаажсанаас хойш шалгуулагчийн овог, нэр Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэлд солигдсон бол шалгуулагч [www.eec.mn](http://www.eec.mn) цахим хуудасны "шалгуулагчийн булан"-аар орж "зөвшөөрөх" товчлуур дарж баталгаажуулна.

2.6 Энэ онд төгсөж буй шалгуулагч сургууль, анги, бүлэг, регистрийн дугаар зөрүүтэй бол сурч буй сургуулийн сургалтын алба /сургалтын менежер/-аар дамжуулан БШУЯ-ны боловсролын салбарын мэдээллийн систем [/esis.edu.mn/](http://esis.edu.mn/)-д мэдээллийг засварласны дараа шалгуулагч [www.eec.mn](http://www.eec.mn) цахим хуудасны "шалгуулагчийн булан"-аар орж "зөвшөөрөх" товчлуур дарж баталгаажуулна.

2.7 Гадаад улс оронд бүрэн дунд боловсрол буюу түүнээс дээш боловсрол эзэмшсэн иргэн шалгалтад бүртгүүлэхдээ бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг гэрчлэх бичиг баримтыг БЕГ-аар баталгаажуулж, БҮТ-д ирж бүртгүүлнэ.

2.8 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тусгай сургуулийн суралцагч ЭЕШ-д хамрагдахаар бүртгүүлсэн бол хүсэлт (ямар нөхцөлөөр шалгалт өгөх боломжтой эсэх), эмчийн магадлагааг бүртгэлийн хугацаанд БҮТ-д ирүүлнэ.

2.9 Шалгуулагч нь бүртгүүлсэн утасны дугаараа ашиглан **133233** тусгай дугаараас өөрийн /нууц дугаар, бүртгэлийн дугаар, шалгалтын хуваарь, судлын хуваарь, дүнгийн мэдээлэл/ мэдээллийг SMS үйлчилгээгээр авах боломжтой.

2.10 Шалгуулагч бүртгэлийн хугацаанд бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан [www.eec.mn](http://www.eec.mn) цахим хуудасны "шалгуулагчийн булан"-д нэвтэрч шалгалт өгөх хичээлээ нэмж болно. Сонгож баталгаажуулсан хичээлийг хасах болон солих боломжгүй.

2.11 МХБШ нь үнэ төлбөргүй бөгөөд ЭЕШ-ын нэг хичээлийн бүртгэлийн хураамж 5800 төгрөг байна.

2.12 Шалгуулагч шалгалтын хураамжийг арилжааны бүх банкны интернэт гүйлгээний эрхтэй төлбөрийн карт болон Qrau үйлчилгээг ашиглан шилжүүлнэ.

2.13 Шалгуулагч бүртгэлээ бүртгэлийн хугацаанд цуцлан шалгалтын хураамжийг эргүүлэн авах хүсэлтээ гаргасан тохиолдолд тухайн шалгуулагчийн бичиг баримт, өргөдөл, төлбөр төлсөн хуулгыг /банкны теллерийн тамгатай/ үндэслэн олгоно.

2.14 Бүртгэл дууссаны дараа ямар нэгэн шалтгаанаар шалгалтад ороогүй тохиолдолд шалгалтын хураамжийг эргүүлэн олгохгүй, бусдад шилжүүлэн тооцохгүй.

2.15 Шалгуулагч бүртгүүлэх явцад төлбөрийн гүйлгээг давхардуулж хийсэн тохиолдолд бүртгэлийн хугацаанд болон бүртгэл дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор БҮТ-д хандаж төлбөрийн буцаалт хийх тухай хүсэлт гаргаж болно.

2.16 2023 онд ерөнхий боловсролын сургууль төгсөж буй бүртгүүлэгч [www.eec.mn](http://www.eec.mn) цахим хуудасны "шалгуулагчийн булан"-аас QR код бүхий "бүртгэлийн хуудас"-аа хэвлэн авч сургуулийн захирлаар гарын үсэг зуруулан, тамга даруулж баталгаажуулна. Харин өмнөх онд төгссөн шалгуулагчийн "бүртгэлийн хуудас" нь QR кодоор баталгаажсан байх ба шууд хэвлэн авна.

## **Гурав. Шалгалтын хугацаа, зохион байгуулалт**

- 3.1 Аймаг, нийслэл (сум, дүүрэг)-ийн шалгалтын байранд БҮТ-өөс томилогдсон шалгалт зохион байгуулах комисс ажиллах ба батлагдсан удирдамжийн дагуу шалгалтыг зохион байгуулна.
- 3.2 Шалгуулагч өөрийн бүртгэлийн дугаар болон нууц үгийг ашиглан "суудлын хуваарь"-аа [www.eec.mn](http://www.eec.mn), [www.eyesh.eec.mn](http://www.eyesh.eec.mn) цахим хуудасны "шалгуулагчийн булан"-аас хэвлэн авна.
- 3.3 Суудлын хуваарь хэвлэн авах хугацааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх бөгөөд болон [www.eec.mn](http://www.eec.mn), Боловсролын үнэлгээний төвийн пэйж хуудас болон шалгуулагчийн и- мэйл хаягаар илгээнэ. .
- 3.4 Тусгай хэрэгцээ шаардлагатай шалгуулагчийн ирүүлсэн өргөдөл, хүсэлт, эмчийн магадалгаа, сургуулийн тодорхойлолтод үндэслэн шалгалтын анги танхим, шалгалтын материалыг тусгайлан бэлтгэнэ.
- 3.5 Элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр ирэхдээ дараах материалыг заавал бүрдүүлж авчирна.Үүнд:
  - 3.5.1 Бүртгэлийн хуудас
  - 3.5.2 Суудлын хуваарь
  - 3.5.3 Иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах баримт бичиг /Иргэний үнэмлэх авах насанд хүрээгүй буюу 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 16 насанд хүрэх шалгуулагч сурч буй сургуулийн захирал эсвэл өөрийн оршин сууж буй орон нутгийн Засаг даргын гарын үсэг, тамгаар баталгаажсан, сүүлийн 3 сарын дотор авхуулсан өнгөт цээж зурагтай тодорхойлолт, төрсний гэрчилгээний хамт авч ирнэ./
  - 3.5.4 Бүрэн дунд боловсролын үнэмлэх, түүнээс дээш боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг.
- 3.6 МХБШ болон ЭЕШ зохион байгуулах хуваарийг Боловсрол, шинжлэх ухааны яамтай зөвшилцөн БҮТ зарлах бөгөөд шалгалтыг орон даяар Улаанбаатар хотын цагаар нэгэн зэрэг эхлүүлж, дуусгана.
- 3.7 Шалгуулагч шалгалтын байранд суудлын хуваарыт заасан хугацаанд ирсэн байх шаардлагатай бөгөөд хуваарилагдсан нэвтрэх хэсгээр дамжин шалгалт өгөх анги, танхимд орж, 10 минутын өмнө суудлаа эзэлсэн байна. Дурдсан хугацаанаас хожимдсон шалгуулагчийг шалгалтад оруулахгүй.
- 3.8 Шалгалтын анги танхимд гар утас, тооны машин, таблиц, томьёоны хураангуй, ном, дэвтэр, ноорог цаас, гарын авлага, цаасан болон электрон толь бичиг, компьютер, таблет, ухаалаг цаг, дуу хураагуур, чихэвч зэрэг бусдад саад болох, хууран мэхлэх зорилготой ямар нэг зүйлийг авч орохыг хориглоно.
- 3.9 МХБШ болон ЭЕШ-ын математик, физик, химийн шалгалтын үргэлжлэх хугацаа 100 минут, монгол хэл, англи хэл, орос хэл, биологи, газарзүй, түүх, нийгэм судлал шалгалтын үргэлжлэх хугацаа 80 минут байна.
- 3.10 Хариултын хуудсыг санамжийн дагуу БҮТ-өөс тавьж олгосон балын харандаагаар тод засваргүй бөглөнө.

3.11 МХБШ-ын задгай хэлбэрийн даалгаврыг шалгалтын дэвтэр дээр хөх, цэнхэр өнгийн үзгэн болон тосон балаар гүйцэтгэнэ.

3.12 Шалгалтын дэвтэр ба хариултын хуудас /цаашид шалгалтын материал гэх-/ ыг тарааснаас хойш шалгалтын анги танхимд зөвшөөрөгдсөн эрх бүхий хүнээс бусад хүн орж, гарахыг хориглоно.

3.13 Шалгуулагч эрүүл мэндийн байдлаас болон хүндэтгэн үзэх бусад шалгаанаар шалгалтын анги, танхимаас гарсан бол шалгуулагчийн гарах хүртлээ хийсэн даалгаврыг дүгнэж зохих оноог өгнэ.

3.14 Шалгуулагч хянач багшийн зааврын дагуу баганан кодыг наана. Шалгалт зохион байгуулах комиссын гишүүд шалгалтын материалыг шалгуулагчдын өмнө тусгайлан бэлтгэсэн дугтуйд хийж битүүмжилнэ.

3.15 Шалгалтын материалыг БҮТ-д төвлөрүүлэн татаж, хадгална.

#### **Дөрөв. Шалгалтын дүн мэдээ**

4.1 Шалгалтын хугацаа дуусмагц, тусгайлан бэлтгэсэн шууд засалтын байранд тухайн шалгалтын хариултын хуудсыг шалгагч машинаар уншуулж, анхны оноог шууд мэдээлнэ.

4.2 Шалгалтын хэмжээст оноог тухайн шалгалтыг зохион байгуулснаас хойш 24 цагийн дотор [www.eec.mn](http://www.eec.mn) цахим хаягийн "шалгуулагчийн булан"-д байршуулна.

4.3 ЭЕШ-ын дүн онооны жагсаалтыг шалгалтыг зохион байгуулснаас хойш 24 цагийн дотор [www.eec.mn](http://www.eec.mn) цахим хуудсанд байршуулан нийтэд зарлана.

4.4 МХБШ-ын дүн оноог шалгалт зохион байгуулснаас хойш 10 хоногийн дотор [www.eec.mn](http://www.eec.mn) цахим хуудсанд байршуулан нийтэд зарлана.

4.5 МХБШ болон ЭЕШ-ын дүн оноо бүхий батламж хуудсыг [www.eec.mn](http://www.eec.mn) болон E-mongolia.mn цахим үйлчилгээний нэгдсэн порталд байршуулах ба дүн онооны жагсаалт зарласнаас хойш шалгуулагч өөрөө хэвлэж авна.

4.6 МХБШ болон ЭЕШ-ын батламж хуудас нь шалгалт өгснөөс хойш 2.6 жил /30 сар/-ийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

4.7 Хүчинтэй хугацаа нь дуусгавар болсон батламж хуудас /дүнгийн тодорхойлолт/ нь их, дээд сургуульд элсэх үндэслэл болохгүй бөгөөд үүнтэй холбоотой хариуцлагыг БҮТ хүлээхгүй.

#### **Тав. Олон улсын шалгалтын үнэлгээг эш-ын үнэлгээнд дүйцүүлэх**

5.1 Олон улсын хөтөлбөрөөр хичээллэн, ерөнхий боловсролын сургууль төгсөгч нь олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын үнэлгээгээ элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээнд дүйцүүлэх болон элсэлтийн ерөнхий шалгалтад хамрагдан аль өндөр үнэлэгдсэн үнэлгээгээрээ их, дээд сургуульд элсэн орж болно.

5.2 Үнэлгээ дүйцүүлэх хүсэлтэй оюутан, суралцагч нь энэхүү журмын 1.2, 1.3-т заасан эрх зүйн баримт бичгийн дагуу МХБШ-д заавал хамрагдсан байна.

5.3 Олон улсын шалгалтын үнэлгээг ЭЕШ-ын үнэлгээнд дүйцүүлэхдээ сүүлийн 1.5 жилийн дотор олгогдсон олон улсын шалгалтын сертификат, дүнгийн хуудсыг үндэслэнэ.

5.4 Дүн дүйцүүлэх хүсэлт хүлээн авах хугацааг БҮТ-ийн [www.eec.mn](http://www.eec.mn) цахим хуудсаар тухайн жилийн ЭЕШ эхлэхээс өмнө зарлаж зохион байгуулна.

5.5 Боловсролын үнэлгээний төв нь үнэлгээ дүйцүүлэх хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэж, үнэлгээг дүйцүүлсэн "Батламж хуудас"-ыг цахимаар олгоно.

5.6 Үнэлгээ дүйцүүлэх хүсэлтэй оюутан, суралцагч нь Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол улсын ЭЕШ-ын үнэлгээнд дүйцүүлэх хүсэлт, холбогдох бичиг баримтыг БҮТ-ийн [www.eyesh.eec.mn](http://www.eyesh.eec.mn) цахим хуудасны "Шалгуулагчийн булан"-д ЭЕШ-д бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтэрч, "Дүйцүүлэх хичээл" гэсэн хэсэгт хандаж ирүүлнэ. Үүнд:

5.6.1 Үнэлгээ дүйцүүлэх тухай хүсэлт

5.6.2 Төрсний гэрчилгээ эсвэл иргэний үнэмлэхийн хуулбар

5.6.3 Үнэлгээнд дүйцүүлэх хөтөлбөрийн сертификат, дүнгийн хуудасны хуулбар

5.6.4 Бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар эсвэл гадаадад бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг гэрчлэх дүйцүүлсэн баримтын хуулбар /зөвхөн өмнөх оны төгсөгч/

5.6.5 Тухайн сургуульд суралцаж буй тухай сургуулийн тодорхойлолт /зөвхөн 12 дугаар ангийн суралцагч/

5.7 Оюутан, суралцагч нь Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол улсын ЭЕШ-ын үнэлгээнд дүйцүүлэх хүсэлтийн хариуг [www.eyesh.eec.mn](http://www.eyesh.eec.mn) цахим хуудасны "Дүйцүүлэх хүсэлтийн хариу" гэсэн хэсэгт регистрийн дугаараараа нэвтрэн орж харна.

5.8 Оюутан, суралцагчдын дүйцүүлсэн оноог ЭЕШ-ын үндсэн жагсаалтад оруулахгүй ба харгалзах хичээлийн жагсаалтад онооны дагуу байршуулж тусад нь жагсаалт үүсгэн БҮТ-өөс их, дээд боловсролын сургалтын байгууллагад хүргэнэ.

5.9 Оюутан, суралцагч нь дүйцүүлсэн онооны "Батламж хуудас"-аар Монгол улсын их, дээд сургуульд элсэн суралцах эрхтэй.

5.10 Дүйцүүлсэн батламж хуудас нь олон улсын шалгалтад хамрагдаж, сертификат, гэрчилгээ авсан өдрөөс хойш 2,6 жилийн хугацаанд хүчинтэй байна.

5.11 Олон улсын шалгалтын үнэлгээгээ элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээнд дүйцүүлсэн тохиолдолд ЭЕШ-аас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

5.12 Олон улсын хөтөлбөрөөр ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа болон төгссөн дотоод, гадаадын оюутан, суралцагч дүйцүүлэх үнэлгээнд хамрагдах боломжтой.

## **Зургаа. ЭЕШ-ын өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх**

- 6.1 МХБШ болон ЭЕШ -ын явц, зохион байгуулалт, шалгалтын материал, дүн оноотой холбоотойгоор иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх 5-7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг БҮТ-ийн захирлын тушаалаар томилно.
- 6.2 БҮТ шалгалтын материал, дүн оноотой холбоотой өргөдлийг шалгальт зохион байгуулж дууссанаас хойш 5 өдөрт багтаан хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.
- 6.3 Бүртгэл болон шалгуулагчийн хувийн мэдээлэлтэй холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бүртгэлийн хугацаанд БҮТ-ийн 70119498, 75779498 лавлах утас, [info@eec.mn](mailto:info@eec.mn) и-мэйл, <https://www.facebook.com/eec.mn/> цахим хуудсаар хүлээн авна. Мөн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж-21, "Сантис" боловсролын төвийн байранд өөрийн биеэр, бичиг баримттайгаа ирж шийдвэрлүүлж болно.
- 6.4 Шалгалтын явц, зохион байгуулалттай холбоотой өргөдлийг бичгээр гаргаж, тухайн шалгалтын байранд томилогдон ажиллаж буй шалгалтын комисс асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.5 Шалгуулагч дүн оноотой холбоотой өргөдөл гаргасан тохиолдолд хариултын хуудсыг үндэслэл болгон шийдвэрлэнэ.

- 6.6 Шалгуулагчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зэрчилтэй холбоотой өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх боломжгүй бөгөөд шалтгаанаа тодорхой заагаагүй болон буцах хаяггүй өргөдлийг хүлээн авахгүй болно.

### **Долоо. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

- 7.1 Бүртгүүлэхдээ бусдын данс, гүйлгээний картын мэдээллийг хууль бусаар ашиглан гүйлгээ хийсэн нь иргэний гомдоор тогтоогдсон тохиолдолд тухайн шалгуулагчийг шалгалтад оруулахгүй.
- 7.2 Энэхүү журмын 3.6-д заасан хугацаа (цаг, минут)-аас хоцорсон болон мөн журмын 3.8-д заасан баримт бичиг бүрдүүлээгүй, хувийн мэдээлэл зөрүүтэй шалгуулагчийг шалгалтад оруулахгүй.
- 7.3 Шалгуулагч шалгалтын даалгаврыг гүйцэтгэхдээ бусдаас дэмжлэг авсан, энэхүү журмын 3.8-д хориглосон зүйлийг ашигласан, бусдад тусалсан, бусдаас тусламж авсан, хоорондоо ярилцах зэргээр бусдад саад учруулсан бол шалгалтын журам зөрчсөнд тооцож, тухайн шалгалтын материалыг хүчингүй болгоно.
- 7.4 Шалгалтад өөрийнхөө оронд хүн оруулсан, бичиг баримтыг хуурамчаар үйлдэн хууран мэхлэхийг завдсан тохиолдолд тухайн шалгуулагчийн бүх шалгалтын дүн оноог хүчингүй болгоно.
- 7.5 Иргэн, хуулийн этгээд нь шалгуулагчийг хууль бус үйлдэл гаргахад дэмжлэг үзүүлсэн, үгсэн хүйвалдсан, нуун дарагдуулсан эсвэл шалгалтын бэлтгэл болон явц, дүн оноотой холбоотой санаатай болон санамсаргүй болон санаатай үйлдлээр, хэвлэл мэдээлэл, цахим сүлжээгээр худал мэдээлэл тарааж байгууллагын нэр хүнд,

хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулж хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.6 Шалгалтад ороход шаардлагатай болон шалгалтын дүн оноотой холбоотой бичиг баримтыг шалгуулагч хуурамчаар үйлдсэн нь нотлогдсон тохиолдолд холбогдох хуулийн байгууллагад хандан хариуцлага хүлээлгэнэ.

#### Найм. Бусад

8.1 BYT нь зохион байгуулсан шалгалтын дүн, оноо, тайлан, үр дүнг олон нийт, боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллага, судлаачдад [www.eec.mn](http://www.eec.mn), [www.stat.eec.mn](http://www.stat.eec.mn) цахим системээр болон хэвлэмэл байдлаар хүргэнэ.

8.2 Шалгалтын үр дүнгийн талаарх мэдээлэл авах хүсэлтээ тухайн байгууллага албан бичгээр BYT-д ирүүлнэ. BYT нь бүх шатны боловсролын болон судалгаа шинжилгээний байгууллагад шалгуулагчдын статистик дүн мэдээ, шалгалтын хичээл тус бурийн дунджаар дүн оноог гаргаж өгч болно.

8.3 Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ. ЭЕШ-ын үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

8.4 Байгалийн болон цар тахлын нөхцөл байдал буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас BYT-ийн захирлын тушаалаар журамд нэмэлт өөрчлөлт оруулж болно.